



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 17 өдөр


Дугаар А/380

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33.1.14 дэх заалт, Коронавируст халдварын /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед нийслэлд хариу арга хэмжээг эрчимжүүлэх түр журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа) нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж)-т тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т үүрэг болгосугай.

САЙД  С.ЭНХБОЛД



• 141211475

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар
сарын 17-ны өдрийн 1880 дугаар тушаалын
хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД НИЙСЛЭЛД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Коронавируст халдварын тархалтын нөхцөл байдалд үндэслэн тандалт, эмнэлгийн тусламжийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор нэгдсэн лавлах төв, эмнэлгийн тусламж, үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэхтэй (цаашид явуулын амбулатори гэх) холбоотой зохион байгуулалтыг энэхүү түр журмаар зохицуулна.
2. КОВИД-19 халдварын нэгдсэн лавлах төвд эрүүл мэндийн шалтгаанаар хандсан иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэхэд явуулын амбулаторийн үйл ажиллагаа чиглэнэ.
3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг холбогдох хууль, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журам, зааврын хүрээнд зөвлөгөө, мэдээлэл, оношилгоо, эмчилгээг хэрэгжүүлнэ.

Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед нэгдсэн лавлах төв, явуулын амбулаторийн үйл ажиллагааны бэлэн байдал, зохицуулалт

- 2.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь:
 - 2.1.1. Нэгдсэн лавлах төвийн программ хангамжийн тогтмол үйл ажиллагаа, бүртгэлжилт, шийдвэрлэлтийн талаарх нэгдсэн зохион байгуулалтыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
 - 2.1.2. Нэгдсэн лавлах төвд ажиллах хүний нөөцийн сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулна.
 - 2.1.3. Явуулын амбулатори болон нэгдсэн лавлах төвийн үйл ажиллагааны уялдаа холбооны зохицуулалтыг бүрэн хариуцна.
 - 2.1.4. Нэгдсэн лавлах төвд ажиллах хүний нөөцийг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн яамны болон нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагатай хамтран шийднэ.
 - 2.1.5. Нэгдсэн лавлах төвийн үйл ажиллагааны журмыг батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
 - 2.1.6. Нэгдсэн лавлах төвд ажиллах хүний нөөцийн ажиллах орчин, халдварын сэргийлэлт, хоолны асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

2.2. Нийслэлийн эрүүл мэндийн газар нь:

- 2.2.1. Явуулын амбулаторид ажиллах тээврийн хэрэгслийн бэлэн байдал, цэвэрлэгээ, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- 2.2.2. Явуулын амбулаторид ажиллах хүний нөөцийн бэлэн байдлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран бүрдүүлнэ.
- 2.2.3. Явуулын амбулаторид шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, хувийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, нөөцийг бүрдүүлнэ.
- 2.2.4. Явуулын амбулаторийн үйлчлэх хүрээний зохицуулалтын хуваарийг гаргана.
- 2.2.5. Явуулын амбулаторийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд явцын хяналтыг хийж, зохион байгуулалтын болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

2.3. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь:

- 2.3.1. Нэгдсэн лавлах төв болон явуулын амбулаторид ажиллах хүний нөөцийг сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, харьцаа хандлагын зарчим, коронавируст халдварын сэргийлэлт, эрэмбэлэн ангилалт, оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлын сургалтад хамруулна.

2.4. Эмнэлгийн ор зохицуулах баг нь:

- 2.4.1. Улсын онцгой комиссын дэргэд коронавируст халдварын "Эмнэлгийн ор зохицуулах баг дараах бүрэлдэхүүнтэй ажиллана.

Эмнэлгийн ор зохицуулах багийн ахлагч:

- Б.Долгорсүрэн, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн мэргэжилтэн

Эмнэлгийн ор зохицуулах багийн гишүүн:

- Х.Бунд-Очир, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн мэргэжилтэн
- Ц.Оюун-Очир, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер
- А.Саранцэцэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ, бэлгийн замаар дамжих халдварын тандалт судалгааны их эмч
- Э.Энхжаргал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Чанарын удирдлага, аюулгүй байдлын хэлтсийн дарга
- Ц.Сонгиносүрэн, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Д.Цэнджав, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Уламжлалт анагаах ухаан сэргээн засах,

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

- 2.4.2. Эмнэлгийн ор зохицуулах баг нь дүүргийн хариу арга хэмжээний баг болон нэгдсэн лавлах төвөөс хандсан эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх иргэнийг мэдээллийн нэгдсэн санг үүсгэн эмнэлзүйн хүндийн зэргээр эрэмбэлсэн жагсаалтыг гаргана.
- 2.4.3. Эмнэлзүйн хүндийн зэргээс эхлэн эмнэлэгт хэвтүүлэх зохицуулалтыг хийнэ.
- 2.4.4. Орны зохицуулалтын талаарх мэдээллийг нэгдсэн лавлах төв болон дүүргийн хариу арга хэмжээний багт хүргэнэ.

Гурав. Эрүүл мэндийн талаар тусламж, үйлчилгээтэй холбоотой дуудлагыг шийдвэрлэх зохион байгуулалт

3.1. Нэгдсэн лавлах төвийн үйл ажиллагаа:

- 3.1.1. Дуудлага авсан оператор иргэний холбогдох мэдээллийг программд бүрэн шивж оруулна.
- 3.1.2. Эрүүл мэндийн асуудлаар хандсан иргэний дуудлагыг зөвлөгөө өгөх эмчийн шугамд холбоно.
- 3.1.3. Эрүүл мэндийн талаар зөвлөгөө өгөх эмч иргэний биеийн байдлыг утсаар үнэлж, дараах арга хэмжээг авна.
 - шинж тэмдэггүй болон хөнгөн шинж тэмдэгтэй иргэнд өөрийгөө хянах, халдвар хамгааллын талаар зөвлөгөө, мэдээллийг өгч, эрүүл мэндийн талаас гарч байгаа өөрчлөлтийн талаар тодруулах шаардлагатай тохиолдолд хандах эрүүл мэндийн байгууллагын холбоо барих утасны дугаарыг өгнө.
 - хүндэвтэр, хүнд шинж тэмдэг илэрсэн, өрхийн Эрүүл мэндийн төв, дүүргийн тандалтын багт бүртгэлгүй болон яаралтай тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэний байршилд ойр явуулын багт биеийн байдлын мэдээлэл, хаяг, холбоо барих утасны дугаарыг өгнө.
- 3.1.4. Иргэнд очиж тусламж, үйлчилгээг үзүүлэх талаар болон халдвар хамгаалал бусад бэлэн байдлыг хангах зөвлөгөөг өгнө.
- 3.1.5. Нэгдсэн лавлах төвийн зохицуулагч явуулын амбулаториос эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай иргэний мэдээллийг Улсын Онцгой комиссын ор зохицуулах багт мэдээллийг уламжилна.

3.2. Явуулын амбулаторийн бүтэц, үйл ажиллагаа:

- 3.2.1. Явуулын амбулаторид ажиллах бүрэлдэхүүн:
 - эмч-1
 - сувилагч-1
 - мэдээлэл хүлээн авах, бүртгэл хөтлөх ажилтан-1
 - Жолооч-1

3.2.2. Явуулын амбулаторид байх эм, эмнэлгийн хэрэгсэл бусад тоног төхөөрөмж:

- даралтын аппарат
- чагнуур
- пульсоксиметр
- КОВИД-19 халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуур
- хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодис
- яаралтай тусламжийн эм, тариа бүхий бикс (яаралтай тусламжийн зайлшгүй шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, гарааны эмчилгээ)
- харилцаа холбооны хэрэгсэл утас
- мэдээлэл оруулах ПОС машин
- өвчтөн зөөвөрлөхөд шаардлагатай хэрэгсэл (дамнуурга гэх мэт)
- хүчилтөрөгчийн баллон, хүчилтөрөгчтэй дэр

3.2.3. Явуулын амбулаторийн үйл ажиллагаа

3.2.3.1. Нэгдсэн лавлах төвөөс өгсөн дуудлагын дагуу очиж, иргэнд үзлэг, оношилгоо, эмчилгээ, коронавируст халдвар илрүүлэх шинжилгээ хийж, гэрийн хяналт, эмчилгээ болон эмнэлэгт хэвтүүлэх шийдвэрийг гаргана.

3.2.3.2. Эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай тохиолдолд нэгдсэн лавлах төвийн зохицуулагчид иргэний биеийн байдлын мэдээллийг утсаар өгнө.

3.2.3.3. Явуулын амбулаторийн эмч дуудлагын дагуу иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийг нэгдсэн лавлах төвийн зохицуулагчид эргэн мэдээлнэ.